



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, дахин үнэлгээ хийсэн, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй нийт 5,850,000.00 (таван сая найман зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ, 2,193,750.00 (хоёр сая нэг зуун ерэн гурван мянга долоон зуун тавин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Өнөржаргал, Үйлдвэр урлалын Политехник коллежийн захирал Д.Буяндэлгэр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталсан хөрөнгийг Үйлдвэр урлалын Политехник коллежийн сургалтын материалаг баазыг бэхжүүлэх зорилгоор, сургалтын дадлагын хичээлд ашиглуулахаар хүлээлгэн өгөх.

2.4.Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, дээрх арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005463
14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн
261 дүгээр тогтоолын хавсралт



Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй Үйлдвэр урлалын Политехник коллежийн
сургалтын дадлагын хичээлд ашиглахаар акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Элентра, 1783 УНӨ, арал№ КМНТ41ВАНУ 246571	2011/ 2011	615,5	5,850,000.00	2,193,750.00	3,656,250.00
	Нийт дүн			5,850,000.00 (таван сая найман зуун тавин мянга)	2,193,750.00 (хоёр сая нэг зуун ерэн гурван мянга долоон зуун тавин)	